



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/191

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.5.4 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 8/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх ажлын тээвэр шатахууны зардалд 2,547,040 (хоёр сая таван зуун дөчин долоон мянга дөчин) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 2,547,040 (хоёр сая таван зуун дөчин долоон мянга дөчин) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгойн албан татварын зардлын бусад хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  С.АМГАЛАН

